ГОВИЙН ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ДАГДАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА
48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.12.05 № 01/187

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар 2015 оны 12 сард зарлагадсан **1,227,640.00** /Нэг сая хоёр зуун хорин долоон мянга зургаан зуун дөчин/ төгрөгийн хүнсний материалыг тайланд тусгаж, өглөгөөр тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/ -т заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т */Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т */Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1 */Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/*-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нягтлан бодох бүртгэлийг хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөх

1000000712

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Говийн ирээдүй цогцолбор сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Э.Дагдан/, нягтлан бодогч /Н.Эрхэмбаяр/ нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН**[1]**:**

АУДИТОР Т.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЗӨВШӨӨРСӨН:**

**ГИЦС:**

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Э.ДАГДАН

НЯГТЛАН БОДОГЧ Н.ЭРХЭМБАЯР

---

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*